Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Цахим боловсролын бодлого, төлөвлөлт хэрэглэгдэхүүн, цахим сургалт, үнэлгээ хариуцсан ахлах шинжээч, Гомбосүрэн Батнэмэх

# 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугаца | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1.1. Сургалтын цахим платформыг хөгжүүлж, онлайн сургалтын хөтөлбөрийг боловсруулан, цахим контент, цахим хичээл боловсруулан бүх насны иргэдэд насан туршдаа суралцахуйг дэмжих боломжийг бүрдүүлэх | | | | | | | |
| 1 | Ахлах ангийн сонгон суралцах хичээлийг цахимаар зохион байгуулах ажлыг өргөтгөнө | Хамрагдсан хүүхдийн тоо | 2024-2024 оны хичээлийн жилд ахлах ангийн сонгон суралцах хичээлийг 10, 11 дүгээр ангид цахимаар зохион байгуулсан. | Ахлах ангийн сонгон суралцах хичээлийг цахимаар зохион байгуулах ажлыг Улсын хэмжээнд 10-12 дугаар ангид зохион байгуулж эхэлнэ. | 2024-2025 оны хичээлийн жилд нийт ахлах ангийн сонгон судлах хичээлийн сонголтыг 9-10 дугаар сард БСМС-ийн суралцагчийн удирдлагын системээр дамжуулан хийлгэсэн бөгөөд 10-р ангийн 45,822, 11-р ангийн 41,628, 12-р ангийн 37178 сурагч хичээл сонголт хийсэн. Түүнээс бүлэг бүрдээгүй 432 /нийслэл-114, аймгийн төв-102, сум-207, баг-8, Солонгос улс дахь-1/ сургуулийн 10-р ангийн 7074, 11-р ангийн 5531 сурагч, 12-р ангийн 4848 нийт 17,453 суралцагч цахим сургуульд суралцаж байна. Эдгээрээс сургууль дээрээ танхимд | 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хяналтын тоонд хүрсэн ч багшийн дутагдал, танхимын хүрэлцээгүйгээс болж 10-р ангийн 409 сурагч, 11-р ангийн 1939 сурагч 12-р ангийн 63 сурагч цахимаар суралцаж байна. Энэ хичээлийн жилд 166 сургуулийн /орон нутгийн-112, нийслэл-54/ 317 багш 10-р ангийн-336 бүлэг, 11-р ангийн- 306,12-р ангийн 246 бүлэг удирдан хичээл зааж байна. 2025-2026 оны хичээлийн жилд сонгон судлах хөтөлбөрийн 16 хичээлээс 10 дугаар ангийн суралцагчид 4 хичээл, 11,12 дугаар ангийн суралцагчид 3 хичээлийг заавал сонгон судлах бөгөөд тус урьдчилсан хичээл сонголтыг улс орон даяар 2025.05.01-ээс 20-ны өдрүүдэд student.medle.mn боловсролын салбарын суралцагчийн системээр хийгдэнэ. Нийт 9,10,11 дүгээр анги /Дараа жил 10-12 дугаар ангид суралцах/-ийн 150,225 суралцагч 510,755 хичээлийг сонгосон байна. | | |
| 2 | Цахим хичээл, контетийн сан бүрдүүлнэ | Цахим хичээл, контентын тоо | 2023 оны жилийн эцсийн байдлаар "Medle" контентын санд ээлжит хичээл | Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурах бичгийн цахим хэлбэрт бүрэн | Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны "Журам батлах тухай" 123 дугаар тушаалаар Ерөнхий боловсролын сургуулийн контентын санг бүрдүүлэх | 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br><br>Нэгжийн даргын |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 9,027, сурах бичиг 147, теле хичээл 4,024, интерактив контент 230, Интерактив дасгал ажлын хуудас 3,500, виртуал лаборатори 805, цахим ур чадвар олгох 413 хичээл байршсан байна. | шилжүүлсэн байна. | журам, 2022 оны "Аргачлал шинэчлэн батлах тухай" А/384 дугаар тушаалаар Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн контент сонгон шалгаруулах аргачлал тус тус батлагдсан бөгөөд журам, аргачлалын дагуу багш нарын дунд нээлттэй сонгон шалгаруулах ажил үргэлжлэн хийгдэж байна. 2024 оны жилийн эцсийн байдлаар "Medle" контентын санд ээлжит хичээл 10,979 үүнээс заавал судлах хичээлийн 9,414, сонгон судлах хичээлийн 1,565 хичээл, сурах бичиг 147, теле хичээл 4,024, интерактив контент 230, интерактив дасгал ажлын хуудас 3,500, виртуал лаборатори 805, цахим ур чадвар олгох 413 хичээл байршсан байна. Мөн Боловсрол шинжлэх ухааны яам Польшийн “Learnetic” боловсролын технологийн компанитай хамтран Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн 33 сурах бичгийн бүх дасгал, даалгаврыг интерактив хэлбэрт шилжүүлсэн байна.<br>Хавсралт: 1 файл | | үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |
| 1.2. Урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан боловсролын салбарт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг тайлагнах. | Цахим боловсролтой холбоотой хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тоо | - | Холбогдох заалтын хэрэгжилт хангаж, биелэлтийг цаг тухай бүр тайлагнана | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны "Журам батлах тухай" 465 дугаартай тогтоолоор батлагдсан "Боловсролын цахим мэдээллийн сангийн систем, техник технологи, программ хангамжийн ерөнхий шаардлага болон төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагатай мэдээлэл солилцох журам"-ын 3.2 дахь заалтыг хэрэгжүүлэхээр боловсролын бүх шатны байгууллагын удирдлагын системийн тусгай шаардлагыг боловсруулан батлуулахад "Дээд боловсролын байгууллагын удирдлагын системийн тусгай шаардлага"-ын төслийг боловсруулан хамтран ажиллаж байна. Боловсролын ерөнхий хуулийн 14.1, 14.2, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 10.4, 10.10, Засгийн газрын 2024 оны 176 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх Боловсролын сайдын "Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, сурах бичгийн эх зохиох, хянах бүрэлдэхүүнй батлах тухай" А/06 тушаалын хавсралтын 3.8.Компьютерийн ухаан | 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хичээлийн ажлын хэсгийн ажилын явцтай танилцса. Ажлын хэсэгт Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Боловсролын ерөнхий газар, Боловсролын үнэлгээний төв, Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн төлөөлөл болон Непко Кидс ХХК, Монголын STEM Боловсролын Академи, Code.org, Scratch Foundation байгууллагуудын албан ёсны төлөөлөгч Кодеркаб ХХК, Японы Artec Co., Ltd-ийн Монгол дахь төлөөлөгчийн газрын төлөөлөл орсон байна. Компьютерын ухаан" шинэ хичээлийг оруулж, хүүхдийн онцлогт тохирсон туршилтын сурах бичиг, дадлага ажлын дэвтрийг боловсруулсан байна. Ерөнхий боловсролын 131 дүгээр сургуульд туршиж байна. Боловсролын ерөнхий хуулийн 35.1, 35.2, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 52.1 дэх хэсгийн дагуу 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/216 дугаар тушаалаар "Ерөнхий боловсролын зарим сургуулийн удирдлагын систем (SMS), суралцахуйн удирдлагын систем (LMS)-ийн суурилуулалт, нэвтрүүлэлт, ашиглалт, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэгжилт, үр дүн"-д хяналт шалгалт хийхээр уг тушаалаар батлагдсан удирдамжийн хүрээнд ажиллаж байна. Хяналт шалгалтад нийслэлийн 12 сургууль хамрагдана.<br>Хавсралт: 3 файл | | |
| 4 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг тайлагнах /2.2.4.Цахимжсан боловсрол/ | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.4.Цахимжсан боловсрол үйл ажиллагааны биелэлт | - | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.4.Цахимжсан боловсрол үйл ажиллагааны биелэлтийг цаг тухай бүр тайлагнах | “Digital Product Conference” нь Дижитал бүтээгдэхүүний салбарын оролцогч талууд, оюутан залуусын салбарын ерөнхий мэдлэгийг тэлэх зорилгоор зохион байгуулагдаж байсан. 2024 онд Боловсролын яамны ивээл дор 5 дахь жилдээ "Боловсролоос Соёл руу" сэдвээр 11 сар Соёлын төв өргөөнд зохион байгуулагдлаа. “Education to Culture” хэлэлцүүлгийн агуулга нь Мэдээллийн технологийн салбарын их дээд сургуулиуд ажил олгогчдын хүлээлтэд нийцэж байгаа эсэх, их дээд сургуульд суралцаж буй оюутан залуус ажлын байранд гарахад байгууллагын соёлтой нийцэж ажиллаж байгаа эсэх талаар илүү олон талын мэдлэгийг хүртээмжтэйгээр хүргэхээр 1000 гаруй мэргэжилтнүүд, бизнес эрхлэгчдэд хүргэхээр зорин | 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ажилласан. Хөтөлбөр нийт 8 илтгэл, 1 панель хэлэлцүүлэг, нэтворкинг хэсгээс бүрдсэн бөгөөд их сургуулийн төлөөллөөр Шинжлэх ухаан технологийн их сургуулийн багш оролцсон. Боловсролын сайдын 2024 оны “Зардал батлах тухай” А/195 дугаар тушаалаар “Digital Product Conference” арга хэмжээнд шаардагдах 10.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Бүгд Найрамдах Солонгос Улсын Санхүү, эдийн засгийн яамнаас эдийн засгийн хамтын ажиллагаатай улс орнуудад тохирсон бодлогын зөвлөгөө өгөх зорилгоор хэрэгжүүлж байгаа KSR төслийн сонгон шалгаруулалт эхэлсэн тухай болон шинэ төслийн санал ирүүлэх Сангийн яамны албан бичигтэй танилцан “Enhancing data use to support transformative change in higher education system of Mongolia”, “Digital transformation of higher education teaching and learning” шинэ төслийн саналыг заасан маягтын дагуу гаргаж хүргүүлсэн. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.11 дэх хэсгийг үндэслэн боловсруулсан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Гэр, бүл, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөдөлмөр хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан тушаалаар батлах "Цахим орчинд хүүхдийг хориотой болон хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам"-ын төсөлтэй танилцан санал хүргүүлсэн.<br>Хавсралт: 2 файл | | |
| 5 | Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнах. | Цахим боловсролтой холбоотой зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь | - | Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна. | Монгол Улсын Их Хурлын 2020 оны "Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай" 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан үйл ажиллагааны 2.1.43, 2.1.44 дэх заалтын хүрээнд Боловсролын яам, Азийн Хөгжлийн Банк хамтран хэрэгжүүлж буй “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн санхүүжилтээр нийслэлийн 3 ээлжээр хичээллэх эрсдэлийг бууруулах зорилгоор Ерөнхий боловсролын 47 сургуульд хосолсон сургалт зохион байгуулахад шаардагдах тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, программ хангамжийг нийлүүлэн энгийн цахим 110, жишиг цахим 25 анги танхим шинээр байгуулж 9 удаагийн сургалтад 337 | 12-р сар | Өөрийн үнэлгээ: 75%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 70%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | багш хамрагдсан. Монгол Улсын Их Хурлын 2020 оны "Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай" 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан үйл ажиллагааны 2.1.43, Засгийн газрын 2024 оны 105 дугаар тогтоолын 1.2, 1.4, 2022 оны 7 дугаар тогтоол, Боловсролын салбарын дунд хугацааны төлөвлөгөөний 1.2.2 дахь заалтын хүрээнд Боловсролын сайдын 2024 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/182 дугаар тушаалаар байгуулагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн Монгол хэлний хичээл, сургалтын чанар, хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор "Монгол хэлний хичээлийн цахим системийг хөгжүүлэх" А/182 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нь “Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн Монгол хэлний хичээл, сургалтын чанар, хэрэглэгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор "Монгол хэлний хичээлийн цахим системийг хөгжүүлэх" ажлын хэсэгт ажиллаж байна. Ажлын хэсэг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 11 сарын 25-д хуралдаж дараах чиглэлээр ярилцсан.Үүнд:1. Ажлын хэсгийн зорилго, үйл ажиллагааны зорилго, чиглэлийг танилцуулах, 2.Бага боловсролын монгол хэлний сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн чиглэл, 3.Бага боловсролын математикийн хичээлд хэрэгжүүлж буй EDUTEN цахим системийн танилцуулга /системийн боломжууд, интерактив даалгавруудын хэлбэр, ач холбогдол зэрэг/ 4.Ажлын хэсгийн төлөвлөгөөний төсөл боловсруулах.<br>Хавсралт: 3 файл | | |
| 6 | Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах | Цахим боловсролтой холбоотой зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь | - | Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна. | Монгол Улсын Их хурлын 2020 оны "Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай" 23 дугаар тогтоолоор батлагдсан журмын 2.1.10 хэрэгжүүлэхээр Боловсролын яам нь Боловсролын Дэлхийн Түншлэл (GPE) олон улсын байгууллагын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” (EQUAL) төслийн хосолсон сургалт бүрэлдэхүүн нь хосолсон сургалтыг | 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 90%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэрэгжүүлэх бодлого, зохицуулалтын тогтолцоог сайжруулах, сурагчийн сурлагын амжилтыг дэмжих зорилгоор нөхцөл байдалд тохирсон хосолсон сургалтын загварыг 5 аймаг 9 дүүргийн нийт 85 ерөнхий боловсролын сургуульд туршин хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Дээрх зорилтот сургуулийн хүрээнд “Хосолсон сургалтыг туршин нэвтрүүлэхэд сурагч, эцэг эх, асран хамгаалагчид, багш нарын оролцоог нэмэгдүүлэх, дэмжлэг үзүүлэх зорилготой цахим контентын уралдааны удирдамж”-ийг хянаж, Төрийн нарийн бичгийн дарга баталлаа. Уг уралдааныг удирдамжийн дагуу зохион байгуулж, уралдааны үр дүнг 2025 оны 03 дугаар сарын 05-ны дотор тайлагнах албан бичгийн Боловсролын ерөнхий газарт 2/2214 тоот албан бичгээр хүргүүллээ. Мөн Тэгш боломжийг бүрдүүлэх суралцахуйг дэмжих төслийн хүрээнд хэрэгжиж байгаа зөвлөх үйлчилгээний багийн боловсруулсан Ерөнхий боловсролын сургуулийн багшийн хосолсон сургалтын чадамжийн хүрээ, багшид тавигдах ур чадварын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нийтлэг шаардлага батлах тухай” төсөлтэй танилцаж дараах ажлыг хийхээр төлөвлөлөө. Үүнд: 1.Хэлэлцүүлэг зохион байгуулах болон дээрх шаардлагын төсөлд санал авах албан бичиг бэлтгэж, холбогдох газарт хүргүүлэх, 2. Хэлэлцүүлэг хийх төлөвлөгөө боловсруулан батлуулах, 3.Саналыг нэгтгэн хэлэлцүүлэх зохион байгуулахаар боллоо. Уулзалтад төслийн зохицуулагч, Ерөнхий боловсролын газрын болон Цахим боловсролын газрын холбогдох албан хаагч, зөвлөх багийн ахлагч нар оролцлоо.<br>Хавсралт: 2 файл | | |
| 1.3. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах | | | | | | | |
| 7 | Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана. | Мэдээллийн тоо, хэрэгжилтийн хувь | - | 1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна. 2. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулсан байна. | Мэдээлэл хариуцагч нээлттэй мэдээллийн ил тод байдлыг хангахад Засгийн газрын 2022 оны 201 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж нийтлэх, шинэчлэх, хяналт тавих нийтлэг журам"-ын дагуу БШУЯ-ны нээлттэй мэдээллийг https://shilen.gov.mn/ цахим системийн шилэн индексийн | 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ: 100%<br>Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тайлан бүртгэл хэсэгт оруулж 86% -ийн гүйцэтгэлтэй үнэлүүлсэн. https://shilen.gov.mn/index | | байдал: 100% |

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| № | Үүрэг даалгавар | Өгсөн субьект | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | | | | | | | |
| 1 | Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | - | Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх | Дараах хууль, тогтоол болон тушаалаар батлагдсан дүрэм, журмыг судалж, хэрэглэж байна. Үүнд: Хууль: Хүүхэд хамгааллын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Киберь аюулгүй байдлын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болов ерөнхий боловсролын тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль болон бусад холбогдох хууль УИХ-ын болон ЗГ-ын тогтоол: | 11-р сар, 12-р сар | Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Монгол Улсын Их хурлын 2020 оны "Алсын хараа 2050 Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бадлого батлах тухай" 52 дугаар тогтоол Монгол Улсын Их хурлын 2020 оны "Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай" 23 дугаар тогтоол Монгол Улсын Их хурлын 20204 оны "Монгол Улсын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 21 дүгээр тогтоол Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 7 дугаар тогтоол Монгол Улсын Засгийн газрын 2023 оны "Журам батлах тухай" 432 дугаар тогтоол /Боловсролын цахим мэдээллийн сангийн бүртгэл, мэдээлэл солилцох, хадгалах, хамгаалах, баяжуулах, ашиглах журам/ Монгол Улсын Засгийн газрын 2023 оны "Журам батлах тухай" 465 дугаар тогтоол /Боловсролын цахим мэдээллийн сангийн систем, техник технологи, программ хангамжийн ерөнхий шаардлага болон төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагатай мэдээлэл солилцох журам/ Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030 болон бусад холбогдох тогтоол. Удирдлагын академийн “Төрийн захиргааны байгууллага дахь гүйцэтгэлийн удирдлага” танхим, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | цахим хосолсон сургалтад 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдрөөс 27-ны өдөр суралцсан. 2024 оны 11 дүгээр сарын 14-ны өдөр танхимын сургалтад суусан. Сургалтад хамрагдсанаар төрийн байгууллагын гүйцэтгэлийн удирдлагын үзэл баримтлал, орчин үеийн хандлага, эрх зүйн зохицуулалтын талаар мэдлэг, гүйцэтгэлээ төлөвлөх, хэмжих, үнэлэх арга зүй, ур чадвараа дээшлүүлсэн. | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

Цахим боловсролын бодлого, төлөвлөлт хэрэглэгдэхүүн, цахим сургалт, үнэлгээ хариуцсан ахлах шинжээч, Гомбосүрэн Батнэмэх
/................................................./ Огноо: .........................